



X/2021


Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15



Үнэмлэхүй бага температур 2021 оны 10 дугаар сард Баян-Өлгий аймгийн Сагсай суманд -25.6°C -д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 10 дугаар сард Дорноговь аймгийн Замын-Үүд суманд $+26.3^{\circ}\text{C}$, үнэмлэхүй бага температур Баян-Өлгий аймгийн Сагсай суманд -25.6°C -д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР ($^{\circ}\text{C}$), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 10 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Хэнтий аймгийн Биндэр суманд 39.0 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Ховд аймгийн Мөст суманд 31 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2021 оны 10 дугаар сард 13-р хороолол, Хайлааст, 248-р цэцэрлэг, 1-р хороолол, Амгалан, Зурагт орчимд $0.060\text{мг}/\text{м}^3$ - $0.211\text{мг}/\text{м}^3$ -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас $0.010\text{мг}/\text{м}^3$ - $0.161\text{мг}/\text{м}^3$ -ээр давсан байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2021 оны 10 дугаар сард Амгалан, 13-р хороолол, Хархорин зах, Баруун дөрвөн зам орчимд $0.058\text{мг}/\text{м}^3$ - $0.082\text{мг}/\text{м}^3$ -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас $0.008\text{мг}/\text{м}^3$ - $0.032\text{мг}/\text{м}^3$ -ээр давсан байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2021 оны 10 дугаар сард Зурагт, 248-р цэцэрлэг, Баруун дөрвөн зам, 32-ын тойрог, Ургах наран хороолол, 1-р хороолол, 13-р хороолол, Хайлааст, Хархорин зах, Баянхошуу орчимд 0.108 мг/м³ – 0.446 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.008 мг/м³ – 0.346 мг/м³-ээр давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.010 мг/м³ (32.0%)-ээр их байсан бол азотын давхар ислийн дундаж агууламж 0.001 мг/м³ (3.0%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.014 мг/м³ (11.6%)-ээр, PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.010 мг/м³ (22.1%)-ээр тус тус бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 10 сард 3203 болж, өмнөх оны мөн үеэс 457 (12.5%) -гоор буурсан байна. Газар хөдлөлт 2021 оны эхний 10 сард 282 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 234 (5.9 дахин)-өөр нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 10 сарын байдлаар нийт 286 хүн амь насаа алдаж өмнөх оны мөн үеэс 54 (23.3%)-ээр нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 10 сарын байдлаар 20.7 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	2020 I-X	2021 I-X	<u>2021 I-X</u> 2020 I-X
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	3 883	4 317	3 660	3 203	87.5
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	29	34	48	282	5.9 ¹
Объектын түймрийн тоо	3 040	3 611	2 752	2 112	76.7
Амь насаа алдсан хүний тоо	189	187	232	286	123.3
Учирсан хохирол, тэрбум төгрөг	18.4	48.1	108.2	20.7	19.1
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	10.2	1.1	0.3	1.1	3.7 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол

Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 12 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

